

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2019-04-02**

Тендер шалгаруулалтын нэр: : Түлхүүр гардуулах нөхцөлтэй "Дундговь аймаг сайнцагаан сумын төвийн хатуу хучилттай зам, 2,8 км" төслийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: **ЗТХЯ/201902106**

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт Түлхүүр гардуулах нөхцөлтэй "Дундговь аймаг сайнцагаан сумын төвийн хатуу хучилттай зам, 2,8 км" төслийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn, хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо: **Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь ажлын нийт төсөвт өртөгийн 70 хувиас багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 3 жил 2017,2016, 2015**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувь байна

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны аль нэг жилд тендерт санал болгож буй үнийн дүнгийн **70** хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

- *Хатуу хучилттай авто зам барих, засварлах тусгай зөвшөөрөл*

- ***Авто зам, гүүрийн хайгуул, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл***

Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна.

Тусгай зөвшөөрлийн хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бол эрх бүхий байгууллагын хугацааг сунгасан тухай шийдвэрийг ирүүлнэ. Хугацааг сунгасан шийдвэр нь тендер зарлагдсан өдрөөс хойшхи хугацаанд байна.

Тусгай зөвшөөрлийн хавсралт болон гэрээг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.

Тендерийн хамт дараах тендерийн баталгаа ирүүлнэ.

22.000.000 /хорин хоёр сая/ төгрөг

Хүчинтэй байх хугацаа: **2019 оны 07 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал.**

Тендерийг **2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 10 цаг 30 минутад Аймгийн Орон нутгийн өмчийн газрын хурлын зааланд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй.**

Дотоодын давуу эрх **тооцно.**

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дундговь аймаг, Орон нутгийн өмчийн газар
Утас: 70593399